

ЧАОЖӨҮ ХАТГАМЛЫН ЗАРИМ ЭЛЕМЕНТИЙГ ЦАЙНЫ САВ БАГЛАА БООДЛЫН ДИЗАЙНД ТУСГАН ХАРУУЛАХ НЬ

Ли Юхуа¹
Баянзулын Мөнхцэцэг^{2*}

¹ Сити их сургуулийн докторант, Улаанбаатар, Монгол улс

² Доктор (Ph.D), дэд профессор, Улаанбаатар, Монгол улс

* Холбоо барих зохиогч: bamuugii@gmail.com

Хураангуй: Хүн төрөлхтний соёл иргэншлийн ололт дэвшил, орчин үеийн техник технологийн үсрэнгүй хөгжилтэй уялдан Хятад улс уламжлалт соёлоо хамгаалан, хөгжүүлэхэд онцгой анхаарч байгаа нь үндэсний соёлдоо хандах хандлагыг бэхжүүлж, улмаар уламжлалт соёлыг өвлөн уламжлах, түгээндэлгэрүүлэх явдал хэдийнээ нийгмийн шинэ хэв маяг болон төлөвшиж байна. Соёлын биет бус өв, үндэстний урлагийн нэг төрөл болохын хувьд Чаожөү хатгамлыг сонгон авч судлах нь олон талын практик ач холбогдолтой. Иймээс бид Чаожөү хатгамлын онцлогийг илэрхийлсэн зураг дүрслэлтэй орчин цагийн цайны сав баглаа боодлын загвар боловсруулахыг зорьсон ба үүний тулд 1. Хээрийн судалгаа, ярилцлагыг ашигласнаар биет бус өвийг эзэмшиж буй өндөр настангуудыг цайны соёлыг тээгч болохыг олж тогтоох, ярилцлага хийж, 2. Цайны сав баглаа боодлын загвар гаргахын тулд түүхэн судалгаа хийж, Европ, Азийн орнуудын цайны савлагааны дизайны харьцуулсан судалгааг хийсэн, 3. Шинэ загвар гаргах туршилт хийж, хэрэглэгчдээс санал асуулга авч загвар боловсруулах ажилдаа тусгасан.

Гадаад дотоодын цайны сав баглаа боодлын дизайны хөгжлийн түүх, өнөөгийн нөхцөл байдлыг харьцуулан судалж, дүн шинжилгээ хийсний үндсэн дээр Чаожөү хатгамал болон *милан шян даньцун*¹ цайтай холбоотой ойлголтыг тодруулж, Чаожөү нутгийн уугуул бүтээгдэхүүн болох *милан шян даньцун үлун* цайг материаллаг тээгч болгон сонгож, “Долоо хоногийн өдөр тутмын цай” хэмээх дизайны ойлголтыг дэвшүүлэн тавьж, энэхүү цайны багцад зориулж Чаожөү хатгамлын онцлогийг илэрхийлсэн зураг дүрслэлтэй орчин цагийн цайны сав баглаа боодлын шинэ загвар гаргасан. Энэхүү судалгаа, туршилтын ажил нь Чаожөү хатгамлаар жишиг болгон бусад соёлын биет болон биет бус өвийг хамгаалах, өвлүүлэн уламжлах тал дээр олон нийтийн мэдлэг, ойлголтыг дээшлүүлж, Чаожөү хатгамлыг залуучууд таньж ойлгон, шинэ чиг хандлага бүхий соёлын нэгэн хэсэг болгосноор түүний урлагийн үнэ цэнийг тод томруунаар харуулж, хадгалан хамгаалж, уламжлуулахад тодорхой хувь нэмэр оруулна хэмээн төсөөлж байна.

¹ Үлун сортын ногоон цайны төрөл, Гуандун мужийн Чаожөү хотын Фэнхуан сууринд үйлдвэрлэдэг, Хятад улсын алдартай цайны нэг юм.



Түлхүүр үг: Хятадын уламжлалт соёл, соёлын биет бус өв, үндэсний урлаг, милан шян даньцун үлун цай

USING SOME ELEMENTS OF CHAOZHOU EMBROIDERY IN TEA PACKAGING DESIGNS

Li Yuhua¹

Munkhtsetseg Bayanzul^{2,*}

¹ Doctoral student of City University, Ulaanbaatar, Mongolia

² Doctor (Ph.D), Associate Professor, Ulaanbaatar, Mongolia

* Corresponding author: bamuugii@gmail.com

Abstract: With the development of technology and the progress of human civilization, the protection and development of traditional Chinese culture have attracted more and more attention from people. It has become a social fashion and national consciousness to strengthen cultural confidence, inherit and promote the great traditional Chinese culture. Chaozhou embroidery, as one of the intangible cultural heritage and folk culture, is of great practical significance to study. Therefore, we aimed to develop a modern tea packaging design with illustrations that express the characteristics of Chaozhou embroidery.

Therefore, we conducted the following studies.

1. The utilization of field research and interviews allowed for the identification and interviewing of elderly individuals who possess intangible heritage as bearers of tea culture.
2. In order to design tea packaging, a historical study was conducted and a comparative study of tea packaging designs in European and Asian countries was conducted.
3. Experiments were conducted to develop new models and surveys were taken from users.

Based on expounding on the development and present situation of tea packaging design between domestic and foreign, this paper points out the concepts of Chaozhou embroidery and Milanxiang, including analyzing and sorting out the existing problems. With the help of Milanxiang, which is one of the Chaozhou specialty tea, as a material carrier to make a design concept of "A weekly tea". To further explore the application of Chaozhou embroidery in the tea packaging design of the new era, the purpose is to arouse people's awareness of the protection and inheritance of further intangible cultural heritage such as Chaozhou embroidery. So that Chaozhou embroidery will be well known by more younger people and become one of the new trends in cultures. And realize the greatest artistic value of Chaozhou embroidery.

Keywords: *traditional Chinese culture, intangible cultural heritage, Chaozhou embroidery, folk culture, tea, packaging design*

Оршил

Олон мянган жилийн түүхтэй Хятадын уламжлалт соёл иргэншлийг тээж ирсэн Хятадын хатгамал чимэглэл нь түүхэн хөгжлийн явцад өөр өөрийн өнгө төрх, онцлогтой байсаар ирсэн бөгөөд үүний дотор Чаожөү хатгамал² (Хуан Яньфань, 2014, 23), Гуанжөү хатгамал³ (Хү Дафэнь, 2014, 5) нь Хятадын алдартай дөрвөн хатгамлын нэг болох кантон бүлгийн⁴ хатгамал чимэглэлд багтдаг байна. Харин Чаожөү хатгамал тухайн орон нутгийн соёлын салшгүй хэсэг болох уламжлалт гар урлалын технологийн хувьд Гуанжөү хатгамлаас ялгаатай бөгөөд Хятадын хатгамал чимэглэлийн дэг дотор технологийн өвөрмөц товгор сүлжих аргатай, нутаг орныхоо бахдам сайхан өнгө төрхийг алтлаг торгон утастай хослуулан хатгаж оёдгоороо алдартай. Гэсэн хэдий ч цаг үеийн хурдацтай хөгжлийг даган хэвлэл мэдээллийн шинэ эрин үед Чаожөү хатгамлыг сонссон ч сонсоогүй юм шиг, мартагдаж үгүй болох зэрэг асуудалтай тулгараад байгаа бөгөөд өв залгамжлал, хамгаалалд санаа тавих шаардлага улам бүр өсөн нэмэгдэж байна. Бид Чаожөү хатгамлыг өвлүүлэн уламжлуулах олон янзын арга замуудыг эрэлхийлсний эцэст хүн бүрийн сайн мэддэг, өдөр бүрийн хэрэглээ болсон өөр нэг уламжлалт зүйлтэй хослуулах нь хамгийн бодит үр дүнд хүрнэ хэмээн үзэж нутгийн нэрийн цайг сонгов. Өөрөөр хэлбэл, орон нутгийн хамгийн алдартай цайны сав баглаа боодлын дизайнд Чаожөү хатгамлын онцлог элементийг ашиглахыг санал болгож байгаа билээ. Иймээс Чаожөү хатгамал дахь урлаг, уран сайхны онцлог шинжийг сав баглаа боодлын дизайнд тусгахдаа хүн бүгдийн сайтар мэдэх цайны соёлоор дамжуулан Чаожөү хатгамлын уламжлалт урлалын мөн чанар, урлагийн үнэ цэнийг илэрхийлэн харуулахад судалгааны зорилго оршино.

Нөгөөтэйгүүр, түүхэн цаг үеэс хамаарч сав баглаа боодол бүр өөрийн гэсэн өвөрмөц шинж тэмдэг, өнгө төрхтэй байсаар ирсэн бөгөөд өдгөө орчин үеийн шинэ чиг хандлага, соёлын нөлөөгөөр хүмүүсийн амьдралыг үзэх үзэл, гоо зүйн таашаал мэдрэмж шинэ тодорхойлолт, ойлголттой болж байна. Чаожөү хатгамлын уламжлалт урлалыг орчин үеийн хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээтэй хослуулан, орчин үеийн гоо зүй, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, Чаожөү хатгамлын онцлогийг илэрхийлсэн зураг дүрслэлтэй сав баглаа боодлыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх боломжтой загвар боловсруулах нь энэхүү судалгааны ажлын зорилго болно. Энэхүү сав баглаа боодлын загварыг гаргаснаар Чаожөү хатгамлыг дэлгэрүүлэн сурталчлах ажлыг эрчимжүүлж, хатгамал чимэглэлийн талаарх зах зээлийн ойлголтыг тэлэхийн зэрэгцээ үндэстний урлагийг эрхэмлэн дээдлэх,

¹ Чаожөү хатгамал: Гуандун мужийн Чаошань нутагт өргөн дэлгэрсэн хатгамал чимэглэлийн ерөнхий нэршил. Гуандун мужийн зүүн хэсэгт орших Чаошань нутгийн Чаожөү, Шаньтөү, Жяэнь хотуудад өргөн тархжээ. Өнөөгийн байдлаар Шаньтөү, Жяэнь хотуудад үндсэндээ мартагдаж үгүй болсон.

² Гуанжөү хатгамал нь Шуньдө, Наньхай, Жуншань, Паньюу, Фешань зэрэг газар нутгийн ардын уламжлалт хатгамал гар урлалын нэг, засаг захиргааны нэгжийн хувьд Гуанжөү мужид багтах тул Гуанжөү хатгамал хэмээн нэрлэжээ.

³ Кантон (Yue) хатгамал нь Гуандун болон Чаожөү хатгамал гэсэн хоёр том урсгалыг багтаасан Гуандун хатгамлын ерөнхий нэршил. Гуанжөү, Хүнаний шян, Сычуаний шү, Жянсуугийн сүжөү хатгамал зэрэг нь Хятадын алдартай 4 хатгамал юм.

соёлын өөртөө итгэх итгэлийг бэхжүүлж, уламжлалт соёл болон орчин үеийн хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээ хамтдаа өсөн дэвжих явдлыг урагшлуулснаар Чаожөү хатгамлын өвөрмөц содон арга технологийг өвлөн уламжлах үйл ажиллагаа үр дүнд хүрнэ хэмээн үзлээ. Уламжлалт Чаожөү хатгамлыг орчин үеийн хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээтэй хослуулж, орчин үеийн гоо зүйн, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн цайны сав баглаа боодлын загвар гаргаж буй нь судалгааны шинэлэг тал болно.

1. Гадаад болон дотоодын цайны сав баглаа боодлын дизайны хөгжлийн түүх, өнөөгийн нөхцөл байдал

1.1 Дотоодын цайны сав баглаа боодлын дизайны хөгжлийн түүх, өнөөгийн нөхцөл байдал

Сав баглаа боодол нь барааны болон хэрэглээний үнэ цэнийг давхар илэрхийлэх чухал арга хэрэгслийн нэг төдийгүй соёлын материаллаг тээгч юм. Хятадын цайны соёл өнө эртний арвин баялаг түүхтэй билээ. Эрт үед цайны гарал үүслийг “茶” (tu-gашуун өвс ногоо гэсэн утгатай) хэмээх ханзаар тэмдэглэж үлдээсэн байдаг ба харин Тангийн үеийн “цайны хутагт” гэж алдаршсан Лү Юу-гийн “Цайны судар”⁵-т (茶经) “茶” (cha-цай) ханзаар тэмдэглэж үлдээсэн байна. Цай хэмээх ундааг нийгээр ууж хэрэглэх болсноор сав баглаа боодол үүсч бий болоход гол хүчин зүйл болжээ. Тан гүрний үед ихэнх бараа таваар цаасан савлагаатай байсан бол (Зураг 1) Сүн гүрний үед хулсны навчинд цайг хадгалах болж (Зураг 2), Мингийн үед сонин содон цайны сав баглаа боодол аажмаар бий болжээ.



Зураг 1. Цаасан боодолтой цай⁶



图3 茶叶饼茶团五子包

Зураг 2. Хулсны навчин боодолтой цай⁷

Өөрчлөлт шинэтгэлийн бодлогоос хойш цайны сав баглаа боодлын дизайн, хийц загварт улам бүр анхаарал хандуулах болсноор олон янзын цайны брэнд, уран нарийн хийц дизайнтай сав баглаа боодол зах зээлд түрэн гарч ирэв. Тухайлбал, “Шицан жуанюань” (私藏庄园 нууцлаг эдлэн газар гэсэн утгатай) цайны сав баглаа боодол дээр “хураасан цай”-г бүтээлч шинэлэг концепцтэй дизайны аргаар өтгөн ой бүхий эдлэн газарт цай тарьж ургуулдаг газар орчныг зургаар дүрслэн харуулж, гадна талын савлагааг нэг нэгээр нь нээж сайхан цайг хүртэнэ гэсэн санааг агуулжээ (Зураг 3-4).

⁵ МЭ 780 онд Лу Юу-гийн бичсэн “Цайны судар” нь Хятадад төдийгүй дэлхий нийтэд цайны талаар бүрэн тодорхой бичиж үлдээсэн цайны нэвтэрхий толь хэмээн нэрлэгддэг эх сурвалж юм.


⁶ http://www.puerh.fr/en/article/origins_of_puerh_tea_aging.htm

⁷ <https://stock.adobe.com/436220690>



Зураг 3-4. Шицан жуанюань цай⁸

“Чажоюгийн үзэмж төгөлдөр найман газрын үлун цай” нь Чажою нутгийн хамгийн алдартай “үзэмж төгөлдөр найман газар”-ыг загварын цөм илэрхийлэл болгож, гаднах хайрцагны дизайныг нээлттэй цонх хэлбэрээр гарган, эртний хийц маягийг орчин үеийн нөхцөл байдалтай уялдуулан тод томруунаар товойлгон харуулснаар байгалийн эрчмийг эртний хотын дүр төрхтэй хослуулан амьдлаг байдлаар харуулсан байна (Зураг 5-6).



Зураг 5-6. Чажоюгийн үзэмж төгөлдөр найман газрын үлун цай⁹

Хятадын шинэ цайны брэнд болох TEATOUCH нь дорнын соёлыг орчин үеийн хэв маягт оруулснаар олон мянган жилийн түүхтэй цайны соёлыг өнөө үеийнхэнд гоо сайхан зураг дүрслэлээр дамжуулан амар хялбар ойлгуулж өгдөг (Зураг 7-8).



Зураг 7-8. Teatouch¹⁰

Үүнээс харвал Хятадын орчин үеийн цайны сав баглаа боодлын загвар нь дизайны үзэл баримтлал, сав баглаа боодлын хийц, материалын сонголт зэрэг тал дээр шинэлэг бүтээлч байдлыг илэрхийлэхийн сацуу уламжлалт соёлыг өвлөн

⁸ <https://www.zcool.com.cn/work/ZNDI3NjUzODA=.html>

⁹ <https://www.zcool.com.cn/work/ZNTYyMDc5NDA=.html>

¹⁰ <https://www.zcool.com.cn/work/ZNDk3NDY0MzY=.html>

залгамжлах, түгээн дэлгэрүүлэхэд тодорхой хэмжээний санаа дэвшүүлж, тухайн цаг хугацаа болон угсаатан үндэстэн харилцан бие биенээ нөхвөрлөж, бодит байдал хийгээд гоо зүйн төгс хослолыг чухалчлан авч үзжээ гэж дүгнэхээр байна.

1.2 Гадаад улс орны цайны сав баглаа боодлын дизайны хөгжлийн түүх, өнөөгийн нөхцөл байдал

Сав баглаа боодлын англи хэл дээрх утга "package" нь "包裹" буюу *боодол, илгээмж* (нэр үг), "把.....打包, 把.....进行推销" эд зүйлийг *боож баглах, аливаа бараа бүтээгдэхүүнийг худалдан борлуулах* (үйл үг) гэсэн утгатай болно.

Эрт дээр үеэс хүмүүн төрөлхтөн хоол хүнсээ хадгалах, зөөвөрлөн авч явахын тулд сав баглаа боодлыг ашиглаж эхэлсэн бөгөөд гадаад улс орны сав баглаа боодлын технологи барууны аж үйлдвэрийн хувьсгал хүртэл Хятадаас хоцронгуй байсан нь барууны орчин үеийн сав баглаа боодлын дизайны хурдацтай хөгжлийг түргэсгэж өгчээ. Дэлхийн улс орнуудын сав баглаа боодлын дизайн нь тухайн нутаг орны соёл, зан заншил, үндэстний онцлог шинж чанарыг тусгасан байдаг. Тухайлбал, Япон хэв шинжийг агуулсан цайны сав баглаа боодлын дизайн нь энгийн онцгойрох зүйлгүй байшин сууц мэт харагдах боловч Япон соёлыг сав баглаа боодлын дизайнд уран нарийн аргаар тусган харуулжээ. Сав баглаа боодолд дүрслэгдсэн дүр, үйл хөдлөлийн төлөв байдал нүдэнд үзэгдэж гарт баригдам, жижиг сажиг нарийн чимхлүүр үйл ажиллагааг тал бүрээр харуулж өгснөөр Японы өвөрмөц содон өнгө аясыг бүрэн дүүрэн мэдрүүлэхээр шийдэгджээ (*Зураг 9-10*).



Зураг 9-10. Япон хэв шинжтэй цайны сав баглаа боодол¹¹

Ман Сити Коффигийн бүтээгдэхүүний нэг Тайландын MANTOWN цай нь шугаман болон хавтгай дүрслэлд зураг шигтгэн оруулж, Тайландын соёлыг тод томруунаар илтгэн харуулсан ба сав баглаа боодол дээр Тайландын соёлд хамаарах зүүлт тайлбарыг нэмж оруулснаар Тайландын соёлыг улам бүр дэлгэрүүлэн сурталчлах үүрэгтэй болсон байна (*Зураг 11-12*).



Зураг 11-12. Тайландын Mantown цай¹²

¹¹ <https://www.shangyexinzhi.com/article/6264975.html>

¹² <https://www.zcool.com.cn/work/ZNDA5NTI2NjA=.html?>

Энэхүү судалгааны ажлын хүрээнд өөрийн орны болон бусад улс орны цайны сав баглаа боодлын дизайны хөгжлийн дэвшилтэт бүтээлч санаа, үзэл баримтлалыг нарийвчлан судалснаар шинэ санаа төрөхийн зэрэгцээ өөрийн уламжлалт соёлоо бүрэн дүүрэн ойлгож хүндэтгэлтэй хандах урьдал доор уг соёлын онцгой шинж чанарыг тод томруунаар харуулах боломж нэмэгдэж байна. Сав баглаа боодлын дизайн нь бүтээгдэхүүний борлуулалтыг нэмэгдүүлэн ахиулах үндсэн үүрэгтэй төдийгүй тухайн бүтээгдэхүүн өөрийн орны уламжлалт соёлын онцлог шинжийг агуулсан байх нь үндэсний соёлыг дамжуулан уламжлуулах, түгээн дэлгэрүүлэх, сурталчлах чухал үүргийг давхар гүйцэтгэж байдаг нь тодорхой байгааг илрүүлснээр судалгааны ажлын зорилгоо биелүүлэх нөхцөл, арга зам ч ойлгомжтой болж ирлээ.

2. “Милан шян даньцун үлун” цайны тухай

Цайны өлгий нутаг гэгдэх Гуандун мужийн Чаожөү-ийн Фэн Хуаншань-д “Милан шян даньцун үлун цайг үйлдвэрлэдэг. Фэнхуан үлун цай”¹³ дотроос шилдэг арван анхилам үнэртэй цайны төрөлд багтах Милан шян даньцун үлун өдөр тутам уухад тохиромжтой, хамгийн хүртээмжтэй сорт бөгөөд уламжлалт үлун цайны амттай. Милан шян даньцун хэмээн нэрлэх болсон учир уг цай тааламжтай сайхан амттай, цахирмаа цэцгийн анхилам үнэр сэнхийсэн, гашуун болоод чихэрлэг амт нь яв цав таарсан, цахирмаа цэцгийн эрхэмсэг сайхан шинжийг агуулсан тул ийнхүү нэрийджээ. Милан шян даньцун үлун цайнд чихэрлэг төмсний амт илт мэдэгдэм, цахирмаа цэцгийн анхилуун үнэр сэнхийсэн, зөөлөн чихэрлэг амттай, уусны дараа амны хөндийд үнэр амтаа удаан хугацаанд барих ба мөн сайн хандлагддаг учраас “олон түмний цай” хэмээн нэрлэх болсон байна. Милан шян даньцун цай зардал багатай нь түүний хоёр шинж чанартай холбоотой. Нэгдүгээрт, Чаожөү нутагт айл өрх бүр уг цайг тариалдаг тул гарц нь үлун цайны жагсаалтыг тэргүүлдэг буюу ургац арвин. Хоёрдугаарт, уламжлалт технологийг ашиглан милан шян даньцун цайг боловсруулдаг тул өртөг харьцангуй бага байдаг. Милан шян даньцун нь үлун цайны төрөл зүйлд багтах ба алтан шаргал өнгөтэй, аагтай чихэрлэг амт бүхий онцлогтой. Энэхүү цай нь ходоод гэдсийг бүлээцүүлж, сэтгэл санааг сэргээн тэтгэж, өөх тосыг багасган, хорт хавдраас урьдчилан сэргийлэх, хөгшрөлтийн эсрэг зэрэг олон талын ашиг тустай¹⁴ гэдгийг Хятад даяар сайн мэддэг болсон, үнэ өртгийн хувьд ч харьцангуй дундаж үнэтэй тул олон нийтэд хүртээмжтэй байдал нь түүгээр дамжуулан үндэсний соёлоо залууст дамжуулж, ойлгуулахад хамгийн тохиромжтой сонголт гэж үзэж байна.


¹³ Фэнхуан даньцун цай нь үлун цайны нэг төрөл, 900 гаруй жилийн өнө эртний түүхтэй. Чаожөү нь муж орны үлун цай тариалдаг 3 нутгийн нэг юм. Фэнхуан даньцун цайны тариалангийн газар Чаожөү Фэнхуан уулын бүс нутаг Гуандун мужийн Чаожөү хотоос хойд зүгт 40 гаруй км-т орших Фэнхуан суурин бөгөөд халуун орны далайн чийглэг цаг агаартай, далайн төвшнээс 800-1500 м хооронд оршдог.

¹⁴ 蜜兰香单丛的功效与作用. 茶文化网[EB/OL]. (2021-12-14)[2023-03-24]. <http://www.zgchawenhua.com/a/zhuanti/chaoshan/24134.html>

3. Чаожөү хатгамлын онолын тойм, хатгамал чимэглэлийн элементийн сонголт

3.1 Чаожөү хатгамлын тухай товч тойм

Чаожөү хатгамал чимэглэл (*товчоор Чао хатгамал*) нь Хятадын алдартай дөрвөн хатгамлын нэг болох кантон хатгамал чимэглэлийн бүлэгт харьяалагдах бөгөөд анх Чаошань нутагт үүсчээ. Чаожөү хатгамал өсөн дэвжих, уруудан доройтох түүхэн хөгжлийн замыг туулж ирсэн бөгөөд дундад иргэн улсаас шинэ Хятад улс байгуулагдах үе хүртэл *гу* хатгамлын нөлөөнд автаж нэг үе *гу* хатгамал хэмээн нэрийдэж байгаад хожмоо 1962 онд өөрийн жинхэнэ нэрээ эргүүлэн авсан байна. Чаожөү хатгамал нь “товойлгон дэвссэн хатгамал”¹⁵, “лууны хайрсны зүү ороох хатгамал”¹⁶ зэрэг өвөрмөц технологитой. Мөн түүнчлэн, эмэгтэйчүүдтэй харьцуулахад Чаожөү нутгийн эрэгтэй хатгамалчдын ур чадвар гойд сайн байдаг. Үүний гол төлөөлөгч болох Лин Жичэн эрэгтэй хүмүүс газар тариалан эрхэлж, эмэгтэйчүүд нэхэж, хатгадаг гэсэн хэвшмэл ойлголтыг эвдсэн төдийгүй бүх хатгамлын төрөл дотор хамгийн ховор үзэгдэл болжээ. Чаожөү хатгамал нь тухайн нутаг орны өнгө төрхтэй, эрт дээр үед Чин гүрний сүүл үеэс өмнө Чаожөү хатгамлан бүтээгдэхүүн ихэвчлэн хэрэгцээ шаардлагыг чухалчилж байсан бол Нань Ян Чуанюэ¹⁷ үзэсгэлэн нээгдсэнээр урлагийн бүтээл болох талаас нь таашаан үзэх болжээ.



Зураг 13. Лууны хайрс сүлжих аргаар хатгасан бүтээл¹⁸



Зураг 14. Сийлбэр адил товойлгон дүрсэлсэн хатгамлан бүтээл¹⁹

¹⁵ “Товойлгон дэвссэн хатгамал” гар урлалын нэг технологи бөгөөд Чаожөү хатгамлын гол онцлог юм. Товойлгон дэвссэн хатгамал хэмээн нэрлэсэн учир нь цаас, хөвөн даавуун дээр зургийн хэлбэр дүрсийг дэвсэж өгсний дараагаар алтан шаргал торгон утсаар хатгаж оёно. Ийнхүү хатгаж оёсон хатгамал сийлбэр урлагийн бүтээл мэт харагддаг байна.

¹⁶ “Лууны хайрсны зүү ороох хатгамал” толгой сүүл хэсэг тус бүр дээр нэг зүү тогтоох ба нэг хайрс 3 цагаригтай, энэхүү цагаригийн чанга сулыг тааруулна. Зөвхөн Чаожөү хатгамалд байх энэхүү арга технологи хатгамал чимэглэлийн харьцангуй хүнд нарийн чимхлүүр ажиллагаанд тооцогддог байна.

¹⁷ <https://baike.baidu.com/item/%E5%8D%97%E6%B4%8B%E5%8A%9D%E4%B8%9A%E4%BС%9A/3700865?fr=aladdin>. 1910 онд зохион байгуулагдсан Хятад улсын хамгийн анхны олон улсын үзэсгэлэн

¹⁸ <http://www.mmca.cn/works/detail?queryMap.id=291>

¹⁹ <http://www.mmca.cn/works/detail?queryMap.id=291>

Өдгөө Чаожөү хатгамал улсын зэрэглэлтэй соёлын биет бус өвийн жагсаалтанд бүртгэлтэй. Цаашид өвлөн залгамжлах хүнгүй, технологи мартагдан устгах, хатгамал хийх хүнгүй болох зэрэг асуудалтай тулгарч байна. Хээрийн судалгааны ажил, холбогдох материалыг эмхлэн цуглуулсны үндсэн дээр нэгдүгээрт, Чаожөү хатгамлын талаар тэмдэглэж үлдээсэн эх сурвалж ховор, хоёрдугаарт, шинэлэг бүтээлч хэлбэрээр олны хүртээл болгосон цөөн хэдэн бүтээлийн дотор сав баглаа боодолтой хослуулан дизайн талаас хийсэн судалгаа тун ховор байгааг олж тогтоосон.

3.2 Чаожөү хатгамлын элементийн сонголт, түүний дизайны ач холбогдол

Чаожөү хатгамлын соёлыг улам бүр хөгжүүлэхийн тулд соёл болоод урлагийн онцлог шинж чанарыг гүнзгийрүүлэн судлах шаардлагатай. Устаж мөхөхийн ирмэгт тулж ирсэн Чаожөү хатгамлын гар урлалын технологийг судлан хадгалан хамгаалж, ахмад үеийн Чаожөү хатгамалчдын их мастеруудын мэргэн ухаан, бүтээлч санааг өвлөн уламжлуулахын тулд хээрийн судалгааны ажлын үеэр Чаожөү хатгамлын соёлыг гүнзгийрүүлэн судалж, Чаожөү хатгамалтай холбоотой зохиол бүтээлийг уншиж судлах явцдаа бүтээн туурвих урам зоригтой болж, Чаожөү хатгамлын олон гайхалтай бүтээлүүд дундаас ахин шинээр загвар гаргах элементийг сонгон авсан юм. Үүнд: “Есөн луугийн хөлт эрдэнийн хүлс”-ээс лууг, “Есөн гардийн хөлт эрдэнийн хүлс”-ээс гардийг, “Галбинга гарди гүйлс”-ээс галбингааг, “Нарс, тогоруу урт насыг бэлгэднэ” зурагнаас тогорууг, “Үүрийн туяа” зурагнаас бялзуухайг, “Дүүлэн нисэх”-ээс загасыг, “Мандарваа шувууны зураг” дотроос шувууг сонгон авахын сацуу галын дөл, өлзий угалзан үүл, мандарваа цэцэг, эртний нарс, гүйлс, бадамлянхуа, бадамлянхуа цэцгийн навч зэргийг туслах дэвсгэр элементээр орчин үеийн дизайны арга техниктэй хослуулан амьдлаг байдлаар харуулахыг хичээсэн билээ (Зураг 15-21).



Зураг 15-20. Сав баглаа боодолд тусгах хатгамалын зургийн эскиз²⁰

²⁰ Self-drawn by the authors

Чаошань нутагт “Өлзий дэмбэрэл, аз хийморь” хэмээх бэлгэдлийн утгыг чухалчлан үздэг тул ихэнх тэмдэгт аз ерөөл, бэлгэ дэмбэрлийн далд санааг агуулж байдаг. Луу хүсэл тэмүүлэл, эрэгтэй хүүхэд, хүчирхэг байдлыг, гарди шувуу өлзий дэмбэрлийн төлөөлөл тэнгэрийн доорх амар амгаланг бэлгэддэг байна. Галбингаа шувуу хорвоо ертөнцийн амгалан тайван байдлыг, тогоруу болон нарс нь урт удаан наслахыг, алтан загас элбэг дэлбэг байдлыг, хос загас аз жаргалыг, хос тоо хосоороо аз жаргалаар дүүрэн байхыг, загас бадамлянхуа цэцэг, бадамлянхуа хээ нь тэнгэр, газар хоорондын зохилдлогоо, эр эм хосоор оршихуйн арга билгийн соёлын тэмдэг болно. Загас, бялзуухай, нарс нь амьд бие махбод ахин сэргэх, амьдралын эрчийн бэлгэдэл юм. Өөд өөдөөсөө харсан хос шувууд “Аз жаргалтай учран золгох” утгыг бэлгэддэг байна.

4. Милан иян даньцун үлун цайны сав баглаа боодлын дизайнд Чаожөү хатгамлын онцлог элементийг сонгон тусгасан нь

4.1 Дизайны санаа

Чаожөү соёл, Чаожөү хүмүүсийн өдөр тутмын амьдралын дадал хэвшилтэй уялдуулан, олон нийтээр сайн мэдэх цайг соёлын тээгч болгон ашиглаж, “*долоо хоног тутмын цай*” гэсэн ойлголтыг бий болгон, уламжлалт эгэл жирийн болон орчин үеийн чиг хандлагыг хослуулан цайны сав баглаа боодлын дизайныг зохион бүтээхийг зорьсон. Долоон янзын байгалийн эд юмсыг долоо хоног тутмын цайг төлөөлөх дүр болгон, түүний дотор Чаожөү хатгамлын мартагдаж устах дөхсөн зүү ороох аргыг Чаожөү хатгамлыг илэрхийлэх дүрслэл болгон оруулж өгсөн. Ялангуяа сав баглаа боодлын дизайнд брайл цагаан толгойн товгор дардсыг нэмж оруулснаар хүмүүс тэр бүр анзаардаггүй тусгай хэрэгцээт бүлэг рүү анхаарлыг нь хандуулж өгсөн юм. Энэ бүх сонголт, шийдлүүдээр хүн бүр, ялангуяа залуучууд үндэсний уламжлалт соёлоо дээдлэн үндэснийхээ урлагийг илүү ихээр таньж мэдэн, мэдлэгээ дээшлүүлэх боломжийг бүрдүүлэхийг чухалчилсан болно.

4.1.1 Бүтээгдэхүүнийг тодорхойлох

Бие махбодыг тэтгэх шинж чанараар нь цайны гол ашиг тусыг тодорхойлдог. Хэрэглэгч хэр хэмжээний цай худалдан авах чадвартай шалгуураар хэрэглэгчдийн худалдан авах чадварыг тодорхойлдог. Насны хувьд 18-30 насны хооронд 90 оноос 2000 он хүртэлх үеийнхэн байх ба цайг таашаан уух дуртай, цайны соёл, Чаожөү хатгамлыг сонирхдог залуучууд, идэр насныхан байхаар тооцоолж сонгосон. Өөрсдөө таашаан уух, цуглуулах эсвэл хэн нэгэнд бэлэглэх зорилгоор худалдан авалт хийх тул үүнийг борлуулалтыг тодорхойлох хэсэгт авч үзэж болно. Сэтгэл зүйн хувьд авч үзвэл, залуучуудын худалдан авалт хийх сэтгэл зүйн шаардлага, эрэлт хэрэгцээг хангаж буй эсэхээр тодорхойлогдоно. Соёлын ойлголтын хувьд Чаожөү хатгамлын онцлог шинжийг харуулахын зэрэгцээ орчин үеийн гоо сайхныг илтгэх загвар дизайныг нэмж оруулан, Чаожөү хатгамлын онцлогийг улам бүр гүнзгийрүүлж өгөхийг зорьсон.

4.1.2 Сав баглаа боодлын дизайны хэв маяг

Орчин үеийн чиг хандлага, залуучуудын хүсэл сонирхлыг хослуулан дизайны хэв маягт орчин үеийн хийгээд энгийн хялбар ерөнхий дизайны ойлголтыг

цогцлоохын тулд эртний уламжлалт хийц дээр орчин үеийн өнгө аястай энгийн хялбар хэв маягийг нэгтгэн, байгаль дэлхийн долоон төрлийн объектыг үндсэн хэсэг болгон илэрхийлэхдээ цагаан өнгөтэй хослуулж, хүндээс хөнгөн рүү шилжих хэлбэрээр илтгэн харууллаа. Үүний дараагаар эртний уран бичлэгийг бүгдэд ойлгогдохуйцаар орчин үеийн өнгө төрх бүхий шинэлэг бүтээлд шигтгээ болгон оруулж өгснөөр уламжлал, орчин үе хэмээх хоёр ойлголт хоорондоо уусан бусдаас содон эрч хүч, таашаан үзэх сонирхлыг тод томруунаар харуулсанд гол утга оршино. Нөгөө талаас орчин үед өргөн дэлгэрсэн *ins* хэв маяг, брайл цагаан толгой мэт зураг дүрсийг бүх гадаргуу дээр бүтээн, *Милан шян даньцун* хэмээн галиг үсгээр буулган, дизайны өндөр түвшний мэдрэмжийг харуулахын тулд энгийн зурган хэлбэрийг хэвлэлийн форматын загварт оруулж шинэчилсэн бөгөөд ингэснээр хэрэглэгчид сав баглаа боодол дахь уламжлалт соёлын үнэ цэнийг шинэ содон визуал хүртэхүйн өнцгөөс бүрэн дүүрэн мэдрэх боломжтой болох юм (*Зураг 22-25*).



Зураг 22-25. Сав баглаа боодол²¹

4.1.3 Дизайны өнгөний зохицол

Тухайн орон нутагт судалгаа хийж, холбогдох материалыг цуглуулсны дараа Чажоёу хатгамал чимэглэлийн бүтээлүүд гоёмсог, хурц тод, баялаг өнгөний зохицолтой, бүхэлдээ тансаг үзэмжит урлагийн гайхам үр нөлөөг илтгэн харуулж, хатгамлын арга барил нь олон янз гэх мэт урлагийн бүтээл гэдгээр ялгарч байна. Энэхүү өнгөний гайхамшигтай онцлогийг харгалзан үзэж хөх, хүрэн улаан, ногоон, ягаан, номин ногоон, хундан шар, улбар шар зэрэг долоон өнгийг сонгон авч, байгаль дэлхийн долоон үзэгдэл тус бүр дээр нэг төрлийн өнгийг нийцүүлэн,

²¹ Self-drawn by the authors

эв зохиролтой, өнгө нь баян тансаг хэв маягийг илтгэн харуулсан билээ. Олон янзын өнгө нь субъектив байдлаар эерэг, баяр баясал, амьдралын эрч хүчийг тусган харуулж харааны хүртэхүйд дээд зэргийн гоо сайхны мэдрэмж, сэтгэлзүйн үр нөлөөг бий болгож, залуучуудын сонирхлыг татсанаар уламжлалт соёлын сав баглаа боодлын талаарх хуучны сэтгэгдлийг халж, сонирхлыг нь татах юм.

4.1.4 Сав баглаа боодлын дизайн зургийг нарийвчлан гаргах

Нэгдүгээрт, брайл цагаан толгойн товгор дардсыг нэмж оруулна. Хатгамал гар урлалын хувьд харааны хүртэхүйгээс гадна хүрэлцэх мэдрэмж чухал байдаг. Тийм ч учраас сав баглаа боодлын нэг талын баруун доод буланд ханзны брайл үсгийг оруулснаар хүрэлцэх мэдрэмжийг нэмэгдүүлж, хүмүүсийн тэр болгон анзаардаггүй, орхигдуулдаг тусгай хэрэгцээт хэрэглэгчдийн бүлгийг анхааралдаа авсан билээ (*Зураг 26*).



Зураг 26. Сав баглаа боодол дээр дүрслэгдсэн брайл үсгийн товгор дардас²²

Хоёрдугаарт, долоон бүтээлийнхээ нэг хэсэгт Чаожөү хатгамлын зүү ороох аргыг ашигласан. Чаожөү хатгамлын зүү ороох арга технологи маш олон төрөл бөгөөд оёж хатгах технологийн талаарх эх сурвалж холбогдох материал байдаггүйн улмаас өнөө цагт зүү ороох хатгамлын талаар бичиж үлдээсэн тэмдэглэл хамгийн чухал үнэ цэнтэй байна. Тиймээс Чаожөү хатгамлын арга технологийг зөв ашиглаж, сурталчлахын тулд зураг дүрслэлд байгаль дэлхийн юмс үзэгдлийг нууцлаг далд байдлаар оруулсан билээ. Тухайлбал, лууны галан бөмбөлөг, гарди шувууны титэм дээр алтлаг утсаар нягт шигүү хатгамал оёж, галбингийн цэцэгс дээр алтан шаргал удвал цэцгийн хэмэрлэгийг хольж хатган, тогоруутай нарс модонд цацраг төрлийн хатгамал, тогосны их биеийг хос зүүний сүлжих оёдлоор хатган оёж, загасны хайрсыг цацраг хясаан оёдол, шувууны сарвуу хэсэгт алхамт оёдлоор хатган, товгор зүү ороох хатгамлын аргыг ашигласан.

Гуравдугаарт, найм дахь цувралд дэлхий ертөнцийн бүх зүйлс хоорондын зохицлын сайн сайхан бэлгэдэлт далд утга санааг агуулсан байна. Долоон төрлийн байгалийн юмс үзэгдэл гурван хэмжээст 3D орон зайгаар хязгаарлагдахгүйгээр объектив ертөнцийг даван гарч, логик учир шалтгааны холбоосгүй эрх чөлөөний

²² Designed by the authors

цогц нэгдлийг харуулсан. Дүрслэлийн онцгой аргаар сэтгэл хөдлөл болон төсөөллийг зоригтойгоор илэрхийлж, цаг хугацаа, орон зайг эвдэн, үзэл бодол пропорциональ харьцаа зэрэгт баригдалгүйгээр байгалийн аливаа юмс үзэгдлийг бүтээлч, эв зохиролтой байдлаар хослуулж, эв нэгдэл, бүрэн бүтэн байдлыг ханган, саад тотгорыг даван, агуу эв нэгдэлд хүрэх сайн сайхан хүсэл эрмэлзлэлийг харуулсан нь уламжлал ба орчин үе, үндэстэн хоорондын цаашлаад дэлхийн улс орнуудын соёлын харилцааг бэхжүүлэх утга санааг агуулсан билээ.



Зураг 27-33. Чаожюү хатгамлын хялбаршуулсан карт²³



Зураг 34. Их цуглаан²⁴

²³ Self-drawn by the authors
²⁴ Self-drawn by the authors

4.2 *Милан шян даньцун* үлун цайны сав баглаа боодлын дизайнд Чаожөү хатгамлын үнэ цэн илрэн гарах нь

Чаожөү хатгамлыг сав баглаа боодлын дизайнд тусган харуулснаар олон нийтэд түгээн дэлгэрүүлж, тухайн соёлыг хүмүүс таашаан үзэж, таньж мэдэх ойлголтыг нэмэгдүүлснээр Чаожөү хатгамлыг сонирхох хүмүүс улам бүр нэмэгдэн, шууд бус байдлаар хүмүүсийн хоорондын зайг ойртуулж, нөхөрсөг харьцааг бэхжүүлнэ. Орчин үеийн залуус өөрийн үндэсний бодит нөхцөл байдалд тулгуурлан, Чаожөү хатгамал, түүний соёлын талаар илүү дэлгэрэнгүй судалгаа хийх шаардлагатай ба Чаожөү хатгамлыг хүлээн зөвшөөрөх, хамгаалах, өв залгамжлалыг чухалчлан үзэх явдалд олон нийтийг удирдан манлайлах үүрэг гүйцэтгэх болно хэмээн төсөөлж байна.

Чаожөү хатгамлын шинэлэг хэлбэрийн шинэ содон өнгө төрхийг олон түмний өмнө нээж өгснөөр үндэсний урлагийн талаарх хуучны хэвшмэл ойлголтыг эвдэж, улмаар дотоодын зах зээлд танигдан борлуулалтын хүрээгээ тэлж, орчин үеийн чиг хандлагыг тодорхойлох юм. Түүнчлэн түүхэн эртний хотын чанад агуулгыг гүнзгийрүүлж, Чаожөү хотын нэр алдрыг түгээн сурталчлахын зэрэгцээ тухайн орон нутгийн эдийн засгийн хөгжлийн нөөц бололцоог урагшлуулж, аялал жуулчлалын салбар хийгээд угсаатны соёлын хөгжлийн хөдөлгөгч хүч болж болох юм.

Дүгнэлт

1. Энэхүү судалгаанд үндэслэсэн сав баглаа боодлын дизайны бүтээгдэхүүний загвар нь Хятадын гайхамшигт уламжлалт соёл, соёлын биет бус өвийн нэг болох Чаожөү хатгамлыг судлан хөгжүүлж, өвлөн уламжлах нь түүнийг устаж үгүй болох, залгамж халаагүй болох зэрэг асуудлыг шийдвэрлэхээс гадна цаашид тасралтгүй хөгжин дэвжиж, цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан уламжлан хамгаалах ажлыг тасралтгүй явуулах эхлэл болох ач холбогдолтой.
2. Мөн түүнчлэн олон нийтэд Чаожөү хатгамлын соёлын үнэ цэн, ойлголтыг мэдрүүлж ойлгуулахад зөвхөн сав баглаа боодлын загвар дизайныг сайжруулж шинэчлэх явдлаар хязгаарлагдахгүй, хөгжлийн шинэ арга замыг нээж, цаг үеийн трендийг нэмснээр Чаожөү хатгамлын *сонгоогоо* хэлбэрийн шинэ тренд чиг хандлага болно. Ингэснээр шинэ эрин үеийн залууст уламжлалт соёлоо өвлөн уламжлах үүрэг хариуцлагаа ухамсарлах, үндэснийхээ соёлын өвийн талаарх ойлголт, мэдлэгээ дээшлүүлэх сонирхлыг нь төрүүлнэ. Үүний үр дүнд өв соёлоо хамгаалах, өвлөн залгамжлах асуудалд зохих хувь нэмрээ оруулах ач холбогдолтойн зэрэгцээ “Милан шян даньцун” үлун цайны эрэлт хэрэгцээ ч өсөн нэмэгдэж, орон нутгийн хөгжилд эдийн засгийн хөшүүрэг болох бололцоотой зэрэг олон олон ач холбогдлыг дурдаж болохоор байна.

Ашигласан материалын жагсаалт

1. Байду нэвтэрхий толь. “Милан Шиан Данконг.” 2023.03.24. <https://baike.baidu.com/item/> (百度百科.”蜜兰香单枞”. 2023.03.24. <https://baike.baidu.com/item/>)
2. Дафэн, Ху. 2014. *Кантоны уламжлалт хатгамал урлалын иж бүрэн цуглуулга*. Бээжин, БНХАУ: Хөнгөн үйлдвэрийн хэвлэл. (胡大芬. 2014. *传统广绣针法工艺全集*. 北京, 中国: 轻工业出版社)
3. Canton Yue Embroidery. 2023.03.24. http://www.cflac.org.cn/gymssy/ctgymsml/cxzmrz/201305/t20130529_193586.html
4. *Кембрижийн толь бичиг*. “Милан Шиан Данконг.” 2023.03.01. <https://dictionary.cambridge.org/zhs> (Cambridge dictionary. “蜜兰香单枞”. <https://dictionary.cambridge.org/zhs>)
5. Роберт, Мак Махон. 2016. *Бүгд Найрамдах Цай: Бүгд Найрамдах Цайны зах зээлийн хувьсгал Цайны экспо*. (罗勃特, 麦克马斯. 2016. *The Republic of Tea: 茶叶共和国的市场革命*. 茶博览)
6. Руйгуан, Хуан. 2006. *Финикс Шанконг*. Бээжин, Хятад Улс: Хятадын хөдөө аж ахуйн хэвлэл. (黄瑞光. 2006. *凤凰单丛*. 北京, 中国: 中国农业出版社)
7. Хятад өнгө. 2023.03.24. <http://zhongguose.com/> (中国色. 2023.03.24. <http://zhongguose.com/>)
8. *Цайны соёлын сүлжээ*. “Зөгийн балны Орхидэйн үнэртэн Данконгийн үр ашигт үйл.” 2023.03.24. <http://www.zgchawenhua.com/a/zhuanti/chaoshan/24134.html> (茶文化网. “蜜兰香单枞的功效与作用”. 2023.03.24) <http://www.zgchawenhua.com/a/zhuanti/chaoshan/24134.html>
9. *Цайны сүлжээний ерөнхий ойлголт*. “Зөгийн балны Орхидэйн үнэртэн Данконг цайны шинж чанар, амт.” 2023.03.24. <https://www.7haocha.com/39223.html> (茶网常识. “蜜兰香单丛茶特点和口感”. 2023.03.24. <https://www.7haocha.com/39223.html>)
10. Шийн, Хуан. 2023. *Хоёр хатгацаар Лууны хайрсыг эргүүлэн хатгах арга: Чаошачуудын гэрийн хатгамал чимэглэл*. Southern Works Daily. (黄细英. 2023. 二针龙鳞转针法.: 承载着潮汕人的美好寄寓. 南方工报)
11. Янфан, Хуан. 2014. *Чаожоу хатгамал*. Гуанжоу, БНХАУ: Линнань дүрслэх урлагийн хэвлэлийн газар. (黄炎藩. 2014. *潮绣*. 广州, 中国: 岭南美术出版社)